



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/130

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт  
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж” худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

3. “Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж” худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР



Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 27-ний өдрийн А/10 дугаар  
захирамжийн хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ХӨВСГӨЛ АРБУЛАГ,  
БҮРЭНТОГТОХ, ЦАГААН-УУЛ, ГАЛТ, ЖАРГАЛАНТ, ТАРИАЛАН, УЛААН-  
УУЛ, ТӨМӨРБУЛАГ, ТҮНЭЛ/ СУМДАД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР  
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Сумын Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	17	100,000,000
2	УАЗ Пургон авто машин /Хөвсгөл Галт, Жаргалант, Раншаат/	3	222,000,000
3	ЗДТГ-т тоног төхөөрөмж /Хөвсгөл, Тариалан сум/	14	50,000,000
4	ЗДТГ-т тоног төхөөрөмж /Хөвсгөл, Улаан-Уул сум/	15	30,000,000
5	ЗДТГ-ын тоног төхөөрөмж тоног төхөөрөмж /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Галт, Улаан-Уул, Төмөрбулаг, Түнэл сум/	96	86,600,000
6	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар багийн засаг дарга, багийн эмч нарт мотоцикл, тоног төхөөрөмж худалдан авах /2022 оны үлдэгдэл/	Кибер Жаал ХХК	104,643,000
		Нарангүрт ХХК	6,667,000
Нийт дүн			599,910,000

оОо